ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мянган угалзат ОНӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/01/**НА-СТА-ОНӨ**

Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2022 он	Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn Аудитор: Б.Должинжав Утас: 89898557 цахим хаяг: Doljinjavb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6
2.5 Зорилтот түвшний гүйцэтгэлийн тайлан 7
3. Аудитын тайлан 7
3.1 Ерөнхий зүйл 7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт 7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 8
3.4 Материаллаг байдал 8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга 8
3.6 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл 9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг 10
3.8 Аудитын гол асуудал 10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал 11
4. Аудитын илрүүлэлт 11
4.1 Залруулсан алдаа 11
4.4 Зөвлөмж 12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл 13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НА	Нотлох ажил

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2022.02.25 № 2/19
танай _____-ны №_____-т

МЯНГАН УГАЛЗАТ
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗРЫН ДАРГА Д.ОТГОНТУЯА ТАНАА

ХЯЗГААРЛАЛТТАЙ ДҮГНЭЛТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Ховд сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Авлага, өглөг зөрүүтэй тооцож бүртгэсэн, харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулаагүй, эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн тооллого хийгээгүй, тооцоо бодож акт үйлдээгүй, санхүүгийн зүй зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүй, нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулаагүй зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцээгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

д/д	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Хөрөнгө	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	807,299.29	65,777.22
1.1.2	Дансны авлага	28,351,102.00	27,999,402.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	-	3,368,460.73
1.1.4	Бусад авлага	234,848.00	234,848.00
1.1.6	Бараа материал	63,665,639.63	64,928,639.63
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	93,058,888.92	96,597,127.58
1.2.1	Үндсэн хөрөнгө	559,845,480.26	466,123,532.89
1.2.2	Биет бус хөрөнгө	240,724,518.25	200,192,974.45
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	800,569,998.51	666,316,507.34
1.3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН**	893,628,887.43	762,913,634.92
2.1.1.1	Дансны өглөг	78,288,684.44	109,718,340.48
2.1.1.2	Цалингийн өглөг	1,126,018.54	7,214,373.29
2.1.1.3	Татварын өр	54,396,961.93	59,941,421.49
2.1.1.4	НДШ - ийн өглөг	28,648,712.83	47,498,097.97
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	162,460,377.74	224,372,233.23
2.2	Өр төлбөрийн нийт дүн	162,460,377.74	224,372,233.23
2.3	Өмч	359,038,740.00	359,038,740.00
2.3.1	төрийн	359,038,740.00	359,038,740.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	548,238,206.00	548,238,206.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(176,108,436.31)	(368,735,544.31)
2.3.11	Эздийн өмчийн дүн	731,168,509.69	538,541,401.69
2.4	**ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН**	893,628,887.43	762,913,634.92

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

д/д	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	147,876,817.72	49,513,319.86
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	25,175,043.60	24,128,042.81
3	Нийт ашиг (алдагдал)	122,701,774.12	25,385,277.05
4	Түрээсийн орлого	-	25,301,500.00
5	Хүүний орлого	-	-
8	Бусад орлого	268,912,586.00	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	29,348,407.99	21,055,712.80
10	Ерөнхий ба удирдлагын зардал	213,332,185.38	181,442,172.25
11	Санхүүгийн зардал	-	784,000.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(130,597,436.27)	(40,032,000.00)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	18,336,330.48	(192,627,108.00)

19	Орлогын татварын зардал	-	-
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	18,336,330.48	(192,627,108.00)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	18,336,330.48	(192,627,108.00)
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	18,336,330.48	(192,627,108.00)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

д/д	Үзүүлэлт	Өмч төрийн	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Эздийн өмчийн дүн
1	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	359,038,740.00	617,114,052.00	-194,444,766.79	781,708,025.21
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	-68,875,846.00	0.00	-68,875,846.00
3	Залруулсан үлдэгдэл	359,038,740.00	548,238,206.00	-194,444,766.79	712,832,179.21
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	18,336,330.48	18,336,330.48
9	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	359,038,740.00	548,238,206.00	-176,108,436.31	731,168,509.69
11	Залруулсан үлдэгдэл	359,038,740.00	548,238,206.00	-176,108,436.31	731,168,509.69
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0	0.00	(192,627,108.00)	(192,627,108.00)
17	**2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл**	359,038,740.00	548,238,206.00	(368,735,544.00)	538,541,402.00

2.4 **Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Төгрөгөөр

д/д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	**Мөнгөн орлогын дүн**	169,796,470.18	75,709,700.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	151,527,200.00	75,637,200.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	15,152.00	0.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	18,254,118.18	72,500.00
1.2	**Мөнгөн зарлагын дүн (-)**	171,098,897.24	76,345,922.07
1.2.1	Ажиллагчдад төлсөн	74,299,868.93	12,933,107.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	32,066,709.00	6,536,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	28,915,140.00	8,099,479.00
1.2.4	Ашиглалтын зардал төлсөн	9,163,273.30	1,601,340.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,754,550.00	1,966,200.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	4,114,340.01	667,941.66
1.2.9	Бусад мөнгөн зарлага	18,785,016.00	44,541,854.41
1.3	**Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	-1,302,427.06	-636,222.07
2	**Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**		
2.1	Мөнгөн орлогын дүн	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн	0.00	75,000.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	75,000.00
2.3	**Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	0.00	-75,000.00
3	**Санхүү үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ**		
3.1	Мөнгөн орлогын дүн	0.00	3,000,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	3,000,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн	0.00	3,030,300.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	0.00	3,000,000.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	30,300.00
3.3	**Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	0.00	-30,300.00
4.1	**Бүх цэвэр мөнгөн гүйлгээ**	-1,302,427.06	-741,522.07
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,109,726.35	807,299.29
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	807,299.29	65,777.22

2.5 **Зорилтот түвшний гүйцэтгэлийн тайлан**

Төгрөгөөр

№	Үзүүлэлт	2021 он		Харьцуулалт	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Нийт орлого :	219,952,000	74,814,820	-145,137,180.14	34%
	Үйл ажиллагааны бусад орлого	219,952,000	74,814,820	-145,137,180.14	34%
2	Нийт зардал	366,556,700	243,313,885	-123,242,814.95	66%
	Үүнээс: Удирдлагын зардал	366,556,700	243,313,885	-123,242,814.95	66%
3	Татварын өмнөх ашиг	-146,604,700	-168,499,065	-21,894,365.19	115%
	Цэвэр ашиг / алдагдал /	-146,604,700	-168,499,065	-21,894,365.19	115%
	Нийт цалингийн сан	107,616,000	66,054,237	-41,561,763.00	61%

3. **Аудитын тайлан**

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мянган угалзат ОНӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусгавар болсон санхүүгийн тайлан, зорилтот түвшний гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд удирдлагын менежмент, нягтлан бодох бүртгэл, тайлагнал, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудлаар зөвлөмж өгсөн болно.

Аудитыг аудитор Б.Должинжав 2022 оны 02 дугаар сарын 07-оос 02 дугаар сарын 14–ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, зорилтот түвшний гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мянган угалзат ОНӨҮГ нь “Ажилчдыг аюулгүй орчинд сэтгэл хангалуун ажиллах, өсөж дэвших боломжоор хангахын зэрэгцээ үйлчлүүлэгчдийн шаардлагад нийцүүлэн чанартай үйлчилгээ үзүүлэх” гэсэн эрхэм зорилгоо тодорхойлон худалдаа аж ахуйн танхим, хүүхдийн парк, Нэвтийн амралтын газрын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна.

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд холбогдох байгууллагаас 2021 онд хяналт шалгалт хэрэгжүүлээгүй байна.

Байгууллагын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд аудитын зорилго оршино.

Мянган угалзат ОНӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьиар бүртгэж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлан гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн үнэлгээнээс хамаарч материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэлсэн учир материаллаг байдлын түвшинг хамгийн ихээр буюу 2 хувиар тогтоосон.

Материаллаг байдлын түвшинг 2021 оны нийт орлого 74.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 1.5 сая төгрөгөөр тооцож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар буюу 1.2 сая төгрөгөөр тогтоов.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мянган угалзат ОНӨААТҮГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 130.7 сая төгрөгөөр буурсны материаллаг нөлөө нь үндсэн хөрөнгийн данстай холбоотой байна. Тайлант хугацаанд эргэлтийн бус хөрөнгө 40.0 сая төгрөгөөр буурч, 94.2 сая төгрөгийн элэгдэл байгуулснаас шалтгаалжээ.

Мөнгөн хөрөнгө оны эхэнд 0.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол оны эцэст 0.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж 0.7 сая төгрөгөөр буурсан байна.

Авлага дансны оны эхний үлдэгдэл 28.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол оны эцэст 31.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж 3.0 сая төгрөгөөр өссөн байна. Эцсийн үлдэгдэл дэх 31.6 сая төгрөгийн авлагын 28.0 сая төгрөг нь дансны авлага, 0.2 сая төгрөг нь он дамжсан ажилчидтай холбоотой эзэн холбогдогч нь тодорхойгүй авлага, 3.4 сая төгрөг нь НӨАТ-ын авлага байна. 28.0 сая төгрөгийн дансны авлагын 75% буюу 21.0 сая төгрөг нь 15 иргэн, аж ахуйн нэгжтэй холбоотой он дамжсан, насжилт өндөртэй, заримын эзэн холбогдогч нь тодорхойгүй авлага, 25% буюу 7.0 сая төгрөг нь тайлант онд үүссэн түрээсийн авлага ба үүнээс 4.2 сая төгрөг нь найдваргүй авлага байна.

Үүнээс дүгнэхэд нийт авлагын 90% буюу 25.2 сая төгрөг нь тооцоо нийлээгүй, найдваргүй авлага байна.

Бараа материал данс оны эхэнд 63.7 сая төгрөг байсан бол оны эцэст 64.9 сая төгрөг болж 1.2 сая төгрөгөөр өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд өөрийн хөрөнгөөр 21.2 сая төгрөгийн бараа материал худалдан авч, 20.0 сая төгрөгийн материалыг үйл ажиллагаандаа зарцуулжээ. Эцсийн үлдэгдэл

дэх 64.9 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийн тооллого хийгээгүй, тооцоо бодож акт үйлдээгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны оны эхний үлдэгдэл 760.8 сая, биет бус хөрөнгийн оны эхний үлдэгдэл 241.5 сая, нийт эргэлтийн бус хөрөнгийн эхний үлдэгдэл 1002.3 сая төгрөг байсан ба тайлант онд 40.0 сая төгрөгийн үнэ бүхий газрыг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 200 дугаар тогтоолоор аймгийн ЗДТГ-ын данс бүртгэлд шилжүүлж, оны эцэст нийт эргэлтийн бус хөрөнгө 962.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Өр төлбөрийн данс оны эхэнд 162.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол тайлант оны эцэст 224.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж 61.9 сая төгрөгөөр өссөн байна. Эцсийн үлдэгдэл дэх 224.4 сая төгрөгийн 109.7 сая төгрөг нь дансны өглөг, 7.2 сая төгрөг нь цалингийн өглөг, 59.9 сая төгрөг нь татварын өр, 47.5 сая төгрөг нь НДШ-ийн өглөг байна.

Тодруулбал:109.7 сая төгрөгийн дансны өглөгийн 92.0 сая төгрөг нь Ховд дулааны станцад халаалтын өглөг, 4.7 сая төгрөг нь ОНӨГ-д түрээсийн орлогын 30 хувь төвлөрүүлэх тооцооны өр, 4.6 сая төгрөг нь ЦТС-ХХК-д гэрэл цахилгааны өр, 8.0 сая төгрөг нь 7 иргэнтэй холбоотой бараа үйлчилгээний зардлын өр төлбөр, 0.3 сая төгрөг нь ҮЭ-ийн он дамжсан өр төлбөр байна.

59.9 сая төгрөгийн татварын өр төлбөрийн 0.1 сая төгрөг нь ААНОАТ-ын өр , 9.1 сая төгрөг нь бусад татварын өр, 37.5 сая төгрөг нь НӨАТ-ын өр, 13.1 сая төгрөг нь ХХОАТ-ын өр төлбөр ба нийт өр төлбөрийн дүн татварын цахим системийн бүртгэл дэх тооцоотой зөрүүтэй байна.

Дээрх өр төлбөрөөс Ховд дулааны станцтай өр төлбөрийн үлдэгдэлд тооцоо нийлж баталгаажуулаагүй, хоорондын эхний үлдэгдлийн тооцоо 5.7 сая төгрөгөөр зөрүүтэй буюу дутуу тусгагдсан, баланс дахь нийгмийн даатгалын шимтгэлийн өр НДХ-тэй оны эхэнд 1.3 сая, оны эцэст 1.8 сая төгрөгөөр зөрүүтэй тусгагдсан, бараа ажил үйлчилгээний зардлын өр төлбөрөөс 2.4 сая төгрөг нь бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо нийлж баталгаажуулаагүй өр төлбөр байна.

Эздийн өмчийн оны эхний үлдэгдэл 731.1 сая төгрөг байсан ба оны эцэст 538.5 сая төгрөг болж 192.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн алдагдлаас шалтгаалжээ.

3.6 **Зорилтот түвшний төлөвлөгөө**, **гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Мянган угалзат ОНӨААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, аймгийн ИТХ-аар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

3.6.1 **Зорилтот түвшний төлөвлөлт**

Аймгийн ИТХ-ын 2021 оны 50 дугаар тогтоолоор Мянган угалзат ОНӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант онд нийт орлогын доод хязгаарыг 219.9 сая, зарлагын дээд хязгаарыг 366.5 сая, үүнээс цалингийн санг 107.6 сая, тайлант үеийн алдагдлыг 146.6 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 **ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ГҮЙЦЭТГЭЛ**

Гүйцэтгэлээр 74.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 243.3 сая төгрөгийн зардал гарган, 168.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Орлогын эх үүсвэрийг тодруулбал: Нийт орлогын 12 хувь буюу 9.1 сая төгрөгийг хүүхдийн паркын үйл ажиллагааны орлого, 31 хувь буюу 23.1 сая төгрөгийг ахуй үйлчилгээний барилгын түрээсийн орлого, 60 хувь буюу 44.0 сая төгрөгийг Нэвт амралтын газрын үйл ажиллагааны орлогоос бүрдсэн байна.

Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлтийн биелэлт, гүйцэтгэлийн шалтгаан нөхцөлийг үзүүлэлт бүрээр танилцуулбал:

Нийт орлогын гүйцэтгэл 145.1 сая төгрөгөөр дутуу буюу 34 хувьтай биелсэн нь Ковид-19-ын нөхцөл байдал, мөн 2012 онд ИТХ-аас тогтоосон хүүхдийн паркын тасалбарын үнэ тарифт өөрчлөлт ороогүй мөрдөгдөж байгаа, тоглоом хуучирч 80 хувь нь ажиллагаагүй, эвдрэл гэмтэл ихтэй, Нэвт амралтын ахмадын ор хоногийн төлбөрийг ХНХЯ-ны сайдын баталсан тарифаар хоногийн 20.0 мянган төгрөгийн хөнгөлөлттэй үнэ тариф мөрдөж ажиллаж байгаатай холбоотой. Мөн бусад шалтгааныг энэхүү тайлангийн 3.8-д аудитын гол асуудал хэсэгт тодруулсан болно

Нийт зардлын гүйцэтгэл 243.3 сая төгрөгт хүрч төлөвлөснөөс 123.2 сая төгрөгөөр дутуу байгаа нь орлогын бүрдүүлэлтээс шалтгаалж зардал буурсан байна

Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын эдийн засгийн ангилал тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

Төлөөлөн удирдах зөвлөл нь хуульд заасны дагуу аймгийн ИТХ-аас баталж томилсон 7 хүний бүрэлдэхүүнтэй байна. ТУЗ-ийн хурлыг 2021 онд 2 удаа зохион байгуулснаар зорилтот түвшний төлөвлөгөө хэлэлцэж, өр төлбөрийн асуудлаас шалтгаалж алдагдалтай төсөв батлуулснаас өөр асуудал шийдвэрлээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй дараах асуудал байна. Үүнд:

ЦТС-ХХК тухайн байгууллагын 2021 оны хүүхдийн паркын гэрэл цахилгааны зардал 6.7 сая төгрөгийг тухайн онд бичилт хийлгүйгээр 2022 оны 1 дүгээр сард бичилт хийснээс шалтгаалж гэрэл цахилгааны өр төлбөр бүртгэгдээгүй байна.

Мянган угалзат ОНӨҮГ-ын эзэмшилд байсан барилга байгууламжийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 05 дугаар тогтоолоор аймгийн ЗДТГ-д шилжүүлсэн байсан ба барилга байрших 400м2 талбайтай 8.0 сая төгрөгийн балансын үнэ бүхий газрыг аймгийн ИТХ-ын 2021 оны 200 дугаар тогтоолоор аймгийн ЗДТГ-ын балансад шилжүүлэх шийдвэр гарсан байна. Гэвч тухайн байршилд буй газар нь Мянган угалзат ОНӨҮГ-ын данс бүртгэлд 40.0 сая төгрөгийн үнэлгээтэй бүртгэгдсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх дараах асуудал байна. Үүнд:

Дулаан, татвар, НДШ-ийн өр төлбөр 199.4 сая, нийт авлагын 90 хувь буюу 25.2 сая төгрөг нь найдваргүй авлага байгаа нь байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад их хүндрэл учруулж байна.

Түүнчлэн тус аж ахуйн нэгж нь ХХҮЕГ-аас зарладаг тендерт оролцоход татвар, НДШ-ийн өр төлбөр өндөртэй учир тодорхойлолт шаардлага хангадаггүй, ахуй үйлчилгээний түрээсийн орлого дулааны төлбөрт ч хүрэлцдэггүй, Нэвтийн амралтын газар төсөв хөрөнгийн гачигдалтай байдгаас урсгал засвар, гадна тохижилтын асуудлыг шийдвэрлэж чаддаггүй, ажилчдын цалин хөлсийг ч бүрэн өгөх нөхцөл бүрддэггүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих мэдээллийг огт мэдээлээгүй нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар үйл ажиллагааны менежментээ сайжруулж, авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулсан эсэхэд, түүнчлэн дансны өглөгт 1.2 сая төгрөг илүү бүртгэгдсэнийг залруулга хийх зүйтэй гэж үзлээ.

Түрээсийн орлого 30 хувь буюу 7.6 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй ч төлбөрийн чадваргүй тул акт тогтоох боломжгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 342.6 сая төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс 12.8 сая төгрөгийн бүртгэлийн 2 алдааг залруулж, 329.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

4.1 **Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. НӨТ авлага дутуу, зардал илүү, үр дүн дутуу тайлагнасан 3.3 сая
2. Цахилгааны зардал, өглөгт 9.5 сая төгрөг илүү бүртгэсэн

4.4 **Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Санхүүгийн удирдлагыг хэрэгжүүлэх талаар**:

Илрүүлэлт: Дулаан, татвар, НДШ-ийн өр төлбөр 199.4 сая, нийт авлагын 90 хувь буюу 25.2 сая төгрөг нь найдваргүй авлага байгаа нь байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад эрсдэл үүсэж байгаад дүгнэлт хийж, шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2-д заасны дагуу байгуулсан гэрээний үүргийн хүрээнд тус аж ахуйн нэгжийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшинд удирдлагаар хангаж ажиллах.

2. **Авлага өр төлбөртэй холбоотой асуудал:**

Илрүүлэлт: Данс бүртгэлд тусгагдсан 25.2 сая төгрөгийн авлагыг холбогдох хуулийн этгээдтэй, өр төлбөрийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Тодруулбал: Ховд дулааны станцтай өр төлбөрийн үлдэгдэлд тооцоо нийлж баталгаажуулаагүй, хоорондын эхний үлдэгдлийн тооцоо 5.7 сая төгрөгөөр зөрүүтэй буюу дутуу тусгагдсан, баланс дахь нийгмийн даатгалын шимтгэлийн өр НДХ-тэй оны эхэнд 1.3 сая, оны эцэст 1.8 сая төгрөгөөр зөрүүтэй тусгагдсан, бараа ажил үйлчилгээний зардлын өр төлбөрөөс 2.4 сая төгрөг нь бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо нийлээгүй, 59.9 сая төгрөгийн татварын өр нь татварын цахим системийн бүртгэл дэх тооцоотой зөрүүтэй байна.

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” 20 дугаар зүйлд заасан нягтлан бодогчийн эрх үүргийн хүрээнд нийцүүлэн баланс дахь авлага, өр төлбөр үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, данс бүртгэлд үнэн зөв тусгах.

3.Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал:

Илрүүлэлт: Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн тооллого хийгээгүй, тооцоо бодож акт үйлдээгүй байна. Мөн байгууллагын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй, хүүхдийн паркын үйл ажиллагааны орлогын үнэт цаас, е-баримтаарх борлуулалтын тооцоо байхгүй, НДШ-ийн тайланд 10.2 сая төгрөгийн цалин хөлснөөс НДШ ногдох орлого зөрүүтэй тооцон тайлагнасан.

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” 20 дугаар зүйлд заасан нягтлан бодогчийн эрх үүргийн хүрээнд нийцүүлэн эд хөрөнгийн тооллого хийж тооцоо бодох, НББББББ боловсруулан мөрдөж ажиллах, үйл ажиллагааны орлогод хэрэгжүүлэх бүртгэлээрх дотоод хяналтыг сайжруулж, үнэт цаасны тооцоо бодож хэвших, е-баримтаар борлуулалтыг мэдээлэх, ажилчдын цалин хөлснөөс НДШ хууль журмын дагуу суутган тооцож, үнэн зөв мэдээлэх, дээрх зөрчлийг цаашид давтан гаргахгүй ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мянган угалзат ОНӨҮГ	5	342.6	2	12.8					3	329.8

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: **Х.БОЛДБААТАР**

АУДИТЫН МЕНЕЖЕР: **А.ЦЭЦЭГСҮРЭН**

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР: **Б.ДОЛЖИНЖАВ**

Мянган угалзат ОНӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мянган угалзат ОНӨҮГ	5	342.6	2	12.8					3	329.8

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: **Х.БОЛДБААТАР**

АУДИТЫН МЕНЕЖЕР: **А.ЦЭЦЭГСҮРЭН**

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР: **Б.ДОЛЖИНЖАВ**